



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/13

Мандалговь

Төгс сод мөнх ХХК-тай гэрээ байгуулах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.2, Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/198 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн дулаарал, цаг агаарын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилт, хуурайшилтын эсрэг модны экологи, эдийн засгийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулан, экологийн боловсролыг дээшлүүлэх замаар аймгийн хэмжээнд “8 ТҮМЭН МОД” тарих ХӨДӨЛГӨӨН-ийг өрнүүлэн мод тарьж, усалж, арчлан ургуулах мэдлэг, дадлага олгох зорилгоор зохион байгуулагдаж байгаа “Дундговио ногооруульяа” төслийн хүрээнд модны суулгац нийлүүлэх ажлыг “Төгс сод мөнх” ХХК-тай гэрээ байгуулсугай.
2. Захиалсан модны нэр төрөл, тоо ширхгээр чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Төгс сод мөнх” ХХК-ний захирал (Д.Туул)-д үүрэг болгосугай.
3. Модны суулгац нийлүүлэх ажилд шаардагдах 9,510,000 (есөн сая таван зуун арван мянга) төгрөгийг аймгийн 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Хүнсний ногоо, ногоон байгууламж эрхлэгчдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр” ажлын батлагдсан зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д, гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

488911-98